



2017 ОНЫ АЙМГИЙН ШИЛДЭГ ТОХИЖИЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ БИЙ БОЛГОСОН ИРГЭН, АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийгмийн хариуцлагыг сайжруулах, тохижилт бүтээн байгуулалт, хог хаягдал, цэвэрлэгээний менежментийг сайжруулах, шинэ санал санаачлагыг дэмжих замаар хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх, иргэдийн ая тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцлийг хангуулахад энэхүү болзолт уралдааны зорилго оршино.

Хоёр. Хугацаа, хамрах хүрээ

2.1. Уралдааныг 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 09 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд зарлан явуулна.

2.2. Уралдаанд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллага, аж ахуй нэгж, иргэн өмчийн төрөл хэлбэр харгалзахгүйгээр хамрагдана.

Гурав. Шалгаруулах ангилал

3.1. Шилдэг иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дараах ангиллын дагуу шалгаруулна.

- 3.1.1 Аж ахуй нэгж байгууллага
- 3.1.2 Төсөвт байгууллага
- 3.1.3 Иргэн

3.2. Шалгаруулалтыг ангилал тус бүрээр удирдамжийн 5 дугаар хэсэгт заагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу явуулна.

Дөрөв. Зохион байгуулалт

4.1. Уралдааны мэдээлэл сурталчилгаа, иргэд аж ахуй нэгж байгууллагыг идэвхжүүлэх ажлыг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулна.

4.2. Уралдаанд оролцох аж ахуй нэгж байгууллага, төсөвт байгууллага, иргэд шалгаруулалт бүтээн байгуулалттай холбоотой мэдээлэл /хашааны өнгө үзэмж,

хаалга, сандал, хогийн сав, хаяг/-ийг ажлын хэсгээс буюу АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс авна.

Дөрөв. Шалгаруулалтын шалгуур үзүүлэлт

4.1. Аж ахуйн нэгж байгууллага:

- 4.1.1. Барилга байгууламжийн гадна өнгө үзэмжийг шинэчлэх, архитектурын чимэглэл хийх
- 4.1.2. Байгууллагын хаягийг стандартын дагуу шинэчлэх, гэрэлтүүлэгтэй болгох
- 4.1.3. Гадна орчны болон талбайн гэрэлтүүлэгтэй байх
- 4.1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, камерын системтэй байх
- 4.1.5. Барилгын гадна тохижилт, авто зогсоол, явган зам, орц гарцын тэмдэг тэмдэглэгээг иж бүрнээр шийдсэн байх
- 4.1.6. Гадна талбайдаа /эзэмшил газрынхаа 10 дээш хувьд/ мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлэх, цэцгийн мандал хийж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байх, ногоон байгууламж хийх талбайгүй тохиолдолд нийтийн эзэмшлийн гудамж талбайд ногоон байгууламж бий болгосон байх
- 4.1.7. Хог тээврийн гэрээ байгуулж, төлбөрийг цаг тухайд нь төлсөн байх
- 4.1.8. Гадна орчныхоо 50 м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, явган хүний замын хогийг тогтмол цэвэрлэж, орчныг бохирдолгүй цэвэр байлгаж, шарилж хогийн ургамлыг түүж цэвэрлэх
- 4.1.9. Нийтийн их цэвэрлэгээний ажилд тогтмол идэвх санаачлагатай оролцох

4.2. Төрийн байгууллага

- 4.2.1. Байгууллагын хаягийг стандартын дагуу шинэчлэх, гэрэлтүүлэгтэй болгох
- 4.2.2. Гадна орчны болон талбайн гэрэлтүүлэгтэй байх
- 4.2.3. Барилга байгууламжийн гадна өнгө үзэмжийг шинэчилж, барилгын гадна тохижилт, авто зогсоол, явган зам, орц гарцын тэмдэг тэмдэглэгээг иж бүрнээр шийдсэн байх
- 4.2.4. Гадна талбайдаа /эзэмшил газрынхаа 10 дээш хувьд/ мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлэх, цэцгийн мандал хийж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байх, ногоон байгууламж хийх талбайгүй тохиолдолд нийтийн эзэмшлийн гудамж талбайд ногоон байгууламж бий болгосон байх
- 4.2.5. Барилгын гадна тохижилт, авто зогсоол, явган зам, орц гарцын тэмдэг тэмдэглэгээг иж бүрнээр шийдсэн байх
- 4.2.6. Гадна орчныхоо 50 м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, явган хүний замын хогийг тогтмол цэвэрлэж, орчныг бохирдолгүй цэвэр байлгаж, шарилж хогийн ургамлыг түүж цэвэрлэх

- 4.2.7. Нийтийн их цэвэрлэгээний ажилд тогтмол идэвх санаачлагатай оролцох
- 4.2.8. Хог тээврийн гэрээ байгуулж, төлбөрийг цаг тухайд нь төлсөн байх
- 4.2.9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, камерын системтэй байх
- 4.3. Иргэн
 - 4.3.1. Хашаа, хашааны хаалгыг будаж, өнгө үзэмжтэй болгох /Гэр хороолол, хувийн орон сууц/
 - 4.3.2. Муу усны нүх, бие засах газар нь байгальд ээлтэй технологиор хийгдсэн, орчин үеийн боловсон байх /Гэр хороолол, хувийн орон сууц/
 - 4.3.3. Гадна орчны гэрэлтүүлэгтэй байх /Гэр хороолол, хувийн орон сууц/
 - 4.3.4. Хашаан дотор тохижилт хийгдсэн байх /Гэр хороолол, хувийн орон сууц/
 - 4.3.5. Эзэмшил болон өмчлөлийн газрын 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж, мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлсэн, цэцгийн мандал хийсэн байх /Гэр хороолол, хувийн орон сууц/
 - 4.3.6. Өөрийн оршин суугаа орцны дотор тохижилтыг сайжруулсан байх /Нийтийн орон сууц/
 - 4.3.7. Орцны гадна тохижилт /хайс, сандал, хогийн сав/-ыг хийж, мод бут, цэцгийн мандал тарьж, зүлэгжүүлсэн байх /Нийтийн орон сууц/
 - 4.3.8. Байрны эргэн тойрны цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, орчныг бохирдолгүй цэвэр байлгаж, шарилж хогийн ургамлыг түүж цэвэрлэх /Нийтийн орон сууц/
 - 4.3.9. Хог тээврийн гэрээ байгуулж, хог гаргасны төлбөрийг цаг тухайд нь төлсөн, төлбөрийн үлдэгдэлгүй байх
 - 4.3.10. Гадна орчныхоо 50 м хүртэлх нийтийн эзэмшил өмчлөлийн газрын хогийг тогтмол цэвэрлэж, орчныг бохирдолгүй цэвэр байлгаж, шарилж хогийн ургамлыг түүж цэвэрлэх
 - 4.3.11. Сум, багаас зохион байгуулсан их цэвэрлэгээний ажилд тогтмол идэвх санаачлагатай оролцох

Тав. Мэдээ тайлан ирүүлэх

5.1. Уралдаанд оролцогч иргэн, аж ахуй нэгж, байгууллага тохижилт, бүтээн байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлангаа шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийн нэр дээр буюу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст 09 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ.

5.2. Тайланд тохижилт, бүтээн байгуулалт хийхээс өмнөх болон дараагийн зураг, зарцуулсан хөрөнгө, оролцогчдын мэдээллийг заавал тусгасан байна.

Зургаа. Шалгаруулалт, шагналын хэмжээ

- 6.1. Шалгаруулалтыг 2017 оны 10 дугаар сарын 15-ны дотор хийнэ.

6.2. Шалгаруулалтыг иргэн, ААНБ-ын ирүүлсэн тайланд үндэслэн, холбогдох байгууллагуудын дүгнэлт, төсөвт байгууллагуудын ажилчдын тоог харгалзан, газар дээр нь үзэж танилцан, явуулна.

6.3. Шагналын сан-14,000,000

- Аж ахуй нэгж байгууллага-2
- Төсөвт байгууллага-2
- Хувийн орон сууц болон гэр хороололд амьдардаг иргэд-6
- Нийтийн орон сууцанд амьдардаг иргэд-6